


# Ковид-19-ийн халдвар авсан хүний анхааралд

Ковид-19-ийн халдвартай хүнийг Эрүүл мэндийн газрын зүгээс эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэх, гэрт нь болон зориулалтын байранд хэвтүүлэх зэрэг зохицуулалт хийх тул зааварчилгааг дагана уу.



- Эрүүл мэндийн газрын хэрэгжүүлдэг **Халдварт өвчний идэвхтэй тандалт судалгаа** (өвчний явц, үйлдэл, хөдөлгөөн, хавьтлыг тодорхойлох)-д хамрагдана уу. Хувь хүний нууцыг чандлан хамгаална.
- Халдвар тархахаас сэргийлэхийн тулд Халдварт өвчний тухай хуульд үндэслэн **ажил хөдөлмөр эрхлэхийг хязгаарлах** арга хэмжээ авна.
- Эмнэлэгт хэвтэх зардлыг **төрийн зүгээс хариуцах** болно. Их өндөр орлоготой хүний хувьд зарим хэсгийг нь өөрөө төлөх шаардлага гарах тохиолдол байдаг.

## Эмнэлгээс гарах, ажил хөдөлмөрийн хязгаарлалтыг цуцлах шалгуур



### Өвчний шинж тэмдэгтэй хүн

- 1) Шинж тэмдэг илэрсэн өдрөөс эсвэл шинжилгээний сорьц авсан өдрөөс хойш 10 хоног өнгөрч байгаа бөгөөд бие сайжирснаас хойш 72 цагийн дараа
- 2) Шинж тэмдэг илэрсэн өдрөөс хойш 10 хоног болоогүй байхад бие сайжирсан бол түүнээс хойш 24 цагийн дараа, PCR шинжилгээ 24 цагийн зайтайгаар 2 удаа авч халдвар илэрч буй эсэхийг шалгана

### Шинж тэмдэггүй вирус тээгч

- 1) Сорьц авсан өдрөөс хойш 10 хоног өнгөрсөн
- 2) Сорьц авсан өдрөөс 6 хоногийн дараа PCR шинжилгээ 24 цагийн зайтайгаар 2 удаа авч халдвар илэрч буй эсэхийг шалгана

Биеийн байдал таагүй байх болон санаа зовж байгаа бол зөвлөлгөө аваарай.



\_\_\_\_\_ -д хандана уу.

(Ажлын өдөр, өдрийн цагаар) \_\_\_\_\_

(Орой болон амралтын өдрөөр) \_\_\_\_\_